



**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 10 өдөр

Дугаар A/205

Улаанбаатар хот

“Эрэл-10” сууц өмчлөгчдийн
холбоонд байр нэмж бүртгэж, гэрчилгээ
шинээр олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.л, 29.2, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянгол дүүргийн 5 дугаар хороо 49 дүгээр байрны оршин суугчдын 2018 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн хурлаар “Эрэл-10” сууц өмчлөгчдийн холбоонд нэгдэх шийдвэр гаргаж холбогдох материалыг ирүүлсэнийг үндэслэн дүүргийн Сууц өмчлөгчдийн холбоодын бүртгэлд бүртгэж, гэрчилгээг шинээр олгох ажлыг зохион байгуулсугай.

2. Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалтын хэвийн байдлыг хангах, сууц өмчлөгчдийн эрх, ашиг сонирхолыг хамгаалах, дундын өмчлөлийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг эрхлэн хариуцах, биелэлтийг ханган ажиллахыг “Эрэл-10” сууц өмчлөгчдийн холбоонд үүрэг болгосугай.

3. Дүүргийн сууц өмчлөгчдийн холбоодын бүртгэлд бүртгэх, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, Нийтийн аж ахуйн хэлтэс /Ж.Ганболд/-т даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Баянгол дүүргийн Засаг даргын 2017 оны А/481 дүгээр захирамжаар бүртгэгдсэн “Эрэл-10” сууц өмчлөгчдийн холбооны 2017 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 252 дугаар гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



С.ОДОНТУЯА